БАТЛАВ

Аймгийн БТСГ-ын даргын түр

орлон гүйцэтгэгч Б.Буянтогтох

.... оны ...... дугаар сарын ...... өдөр

**Санхүүгийн баримт бичгийн төлөвлөлт, зарцуулалт ба хариуцсан ажилтны ажлын гүйцэтгэлд хийх хяналт шалгалтын удирдамж**

Чойр хот

**Нэг.Хяналт шалгалтын ажлын зорилго**

1.1. 2020 оны Байгууллагын санхүүгийн баримт бичгийн аудитын дүгнэлт, 2021 оны төлөвлөлт, зарцуулалт ба хариуцсан ажилтны үйл ажиллагаа, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар зохих арга хэмжээ авч, усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг сайжруулах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахад оршино.

**Хоёр.Хяналт шалгалтын чиглэл, ажлын зохион байгуулалт**

2.1. Хяналт шалгалт нь эрсдэлийн үнэлгээний судалгаагаар гарсан эрсдэл өндөртэй үйл ажиллагааг хамааруулж үзнэ.

2.1.1. 2020 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт

2.1.2 Санхүүгийн ажилтны ажлын гүйцэтгэл

2.1.3 Санхүүгийн баримт бичгийн төлөвлөлт, зарцуулалт

**Гурав.Хяналт шалгалт явуулах, дүгнэх,тайлагнах**

3.1. Хяналт шалгалтын ажилд захиргаа аж ахуй, санхүү хариуцсан ажилтан нягтлан хамрагдах ба шаардлагатай тохиолдолд дээд албан хаагчдыг татан оролцуулж болно.

3.2. Хяналт шалгалт нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хөнгөн шуурхай, удирдамжид заасан хугацаанд явагдах ба шалгагдагч алба нь шалгагдах болон шалгаж буй ажилтнуудыг ажиллах боломж нөхцлөөр хангаж, шаардлагатай баримт мэдээллийг гаргаж өгнө.

3.3. Хяналт шалгалтыг удирдамжийн хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн, үр дүнг холбогдох удирдлагад танилцуулж мэдээлнэ.

3.4. Хяналт шалгалт явуулж буй ажилтнууд нь шалгалтын явцад илэрсэн ажлын ахиц, дэвшилттэй шинэлэг байдал, зөрчил дутагдал зэрэг нөхцөл байдлыг нотлох бүхий л боломжтой арга хэлбэрийг сонгож хэрэглэх ба шаардлагатай тохиолдолд бодит байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг, цаасан болон цахим байдлаар баталгаажуулна.

**Дөрөв. Ажлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Хяналт шалгалтын дүн, илтгэх хуудсыг хяналт шалгалт явуулсан өдрөөс хойш ажлын 10-15 хоногт багтаан хяналт шалгалт явуулсан албанд хүргүүлнэ.

4.2. Ажлын явцад хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилтэд зөрчил дутагдал илэрсэн бол хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулах ба хууль тогтоомжийн хэрэгжилтийг ноцтой зөрчсөн бол байгууллагын байцаагчийн үүднээс хуулийн хариуцлага тооцно .

Удирдамж боловсруулсан:

Дотоод хяналт хариуцсан ажилтан [signature] М.Батдэлгэр

2021 оны 06 дугаар сарын 07 өдөр

**Шалгуур үзүүлэлт**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Үр дүнгийн үнэлгээ | |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн ажилтны ажлын гүйцэтгэл | Ажлын төлөвлөгөө | 10 | 10 |
| | | Ажлын гүйцэтгэлийн тайлан | 10 | 8 |
| 2 | Санхүүгийн баримт бичгийн төлөвлөлт, зарцуулалт | Тэмцээний удирдамж, мэдүүлэг, төсөв хугацаандаа ирдэг эсэх. | 10 | 10 |
| | | Бэлэн мөнгө хариуцан авсан дасгалжуулагч цаг тухайд санхүүгийн тайланг тайлагнаж байгаа эсэх. | 10 | 8 |
| | | нийтийн биеийн тамир хэмжээний зардлын баримтын бүрдэлт | 10 | 10 |
| ҮНЭЛГЭЭ | | | | |
| ХУВЬ | | | | |

Дундаж оноог гаргахдаа авсан нийт оноог дүгнэсэн үзүүлэлтийн тоонд хувааж гаргана.

ДҮГНЭСЭН:

........ажилтан ........ Ш.Ганзориг........

ТАНИЛЦСАН:

........Ня-бо........ ........[illegible]........

2021 оны ..06.. сарын ..07.. өдөр

**Санхүүгийн баримт бичгийн төлөвлөлт, зарцуулалт ба хариуцсан ажилтны ажлын гүйцэтгэлд**

**хийсэн хяналт шалгалтын зөвлөмж**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Зөвлөмж |
|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн ажилтны ажлын гүйцэтгэл | Ажлын төлөвлөгөө | Ажлын төлөвлөгөөг гарган хагас, өүтэн жилээр тайлагнадаг. Төлөвлөгөөний дагуу тайлангууд гүйцэт гаргах үүрэг өгсөн. |
| | | Ажлын гүйцэтгэлийн тайлан | |
| 2 | Санхүүгийн баримт бичгийн төлөвлөлт, зарцуулалт | Тэмцээний удирдамж, мэдүүлэг, төсөв хугацаандаа ирдэг эсэх. | Коронавирус халдварт өвчин гарсантай холбогдуулан тэмцээн уралдааны хааж, тэмцээн уралдааны зардал гаргаагүй болно. Нийтийн биеийн тамирын хүрээнд иргэдийн дархлаа дэмжих зорилгоор цахим хэлбэрээр зохион байгуулж буй арга хэмжээнд зарцуулалтыг . |
| | | Бэлэн мөнгө хариуцан авсан дасгалжуулагч цаг тухайд санхүүгийн тайланг тайлагнаж байгаа эсэх. | |
| | | Нийтийн биеийн тамирын арга хэмжээнийн зардлын баримтын бүрдэлт | аймгийн хэмжээнд цахим арга хэмжээний санхүүгийн бүрдэлтийг тухай бүр авч, холбогдох баримтыг бүрдүүлсэн байна. |

Зөвлөмж бичсэн:Хяналт шалгалт хариуцсан ажилтан: [signature] М.Батдэлгэр